ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДУА-2024/06/НА-СТА-ТТЗ**


Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал
Утас: 70592225
Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ikhbayard@audit.gov.mn

Аудитор: Ж.Угтахбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn



Цахим хуудас: www.audit.mn
Дундговь аймаг
2023 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


........................................................................................................0
1.Аудитын санал дүгнэлт ........................................................................2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл..................................4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан..................................................4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан...............................................4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.............................5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....................................................5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан..................................................6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .......................................6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.............................. **Error! Bookmark not defined.**
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ................................**Error! Bookmark not defined.**
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ................................**Error! Bookmark not defined.**
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.........................**Error! Bookmark not defined.**
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .......... **Error! Bookmark not defined.**
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....................**Error! Bookmark not defined.**
4. Аудитын тайлан ........................................................ **Error! Bookmark not defined.**
4.1 Ерөнхий зүйл........................................................................**Error! Bookmark not defined.**
4.2 Материаллаг байдал...............................................................**Error! Bookmark not defined.**
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.............................**Error! Bookmark not defined.**
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.. **Error! Bookmark not defined.**
4.4.1 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .......... **Error! Bookmark not defined.**
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт. **Error! Bookmark not defined.**
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал...............................**Error! Bookmark not defined.**
5. Аудитын илрүүлэлт ..............................................................................6
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ..........................................16


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

## 1.Аудитын санал дүгнэлт

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р бал, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2024-03-25 № 122

танай ................ -ны № ................ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГА О.УУГАНБААТАР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 114.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч, 250.0 сая төгрөгийн хөрөнгийг хассан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

**Аудитын гол асуудал**

Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Орон нутгийн хөгжлийн сан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ 2022 онд барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралтын ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой зөрчлийг арилгах "хугацаатай албан шаардлага"-ын биелэлтийг хангаагүй, зөрчлийг давтан гаргасан, 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөлтийг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй (Зураг төсөвгүй, сумын урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг

тусгагдаагүй төсөл арга хэмжээг жагсаалтад оруулсан), хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй зэрэг зөрчлүүд нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитаар эрсдэл өндөр үнэлэгдсэн асуудал байлаа.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилт, 98 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 86.4 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*/Мян.төг/*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 977,240.3 | 1,718,344.0 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 624,398.4 | 1,237,736.7 |
| 33 | АВЛАГА | 125,885.4 | 233,160.2 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 0.0 | 0.0 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 82,665.6 | 82,700.8 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 0.0 | 0.0 |
| 360 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 144,290.9 | 164,746.2 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,453,427.0 | 1,317,440.2 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,453,427.0 | 1,317,440.2 |
| 39100 | Газар | 0.0 | 0.0 |
| 39200 | Биет хөрөнгө | 1,442,612.8 | 1,295,101.2 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 10,814.2 | 22,339.0 |
| 39400 | Бусад хөрөнгө /ТӨҮГ/ | 0.0 | 0.0 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,430,667.2** | **3,035,784.2** |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 39,101.8 | 44,325.1 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 39,101.8 | 44,325.1 |
| 41300 | Өглөг | 39,101.8 | 44,325.1 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 2,391,565.4 | 2,991,459.0 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 2,391,565.4 | 2,991,459.0 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 452,108.8 | 452,108.8 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 1,734,300.9 | 2,334,194.5 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 205,155.7 | 205,155.7 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,430,667.2** | **3,035,784.2** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*/Мян.төг/*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,099,117.6 | 1,834,656.2 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 293,788.4 | 822,513.6 |
| 110 | Орлогын албан татвар | 113,035.6 | 174,073.9 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 113,035.6 | 174,073.9 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 34,740.5 | 41,982.6 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 146,012.3 | 606,457.1 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 201,272.1 | 230,751.6 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 201,272.1 | 230,751.6 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 604,057.2 | 781,391.0 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 834,600.7 | 929,831.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 834,600.7 | 929,831.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 664,767.5 | 817,492.4 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 241,244.6 | 339,212.9 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 30,568.7 | 43,339.4 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 13,941.9 | 14,001.5 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 40,093.8 | 58,531.6 |
| 2105 | Нормативт зардал | 0.0 | 0.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,738.4 | 300.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 11,622.0 | 14,862.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 26,453.6 | 31,047.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 298,104.5 | 316,197.3 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 169,833.2 | 112,338.6 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 264,516.9 | 904,825.2 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 0.0 | 0.0 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 3,440,883.0 | 304,931.5 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | -3,176,366.1 | 599,893.6 |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*/Мян.төг/*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| 1 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 5,627,616.9 | 5,627,616.9 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -59,635.4 | -59,635.4 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 5,567,981.4 | 5,567,981.4 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -50.0 | -50.0 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | -3,176,366.1 | -3,176,366.1 |
| 10 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,391,565.4 | 2,391,565.4 |
| 11 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 2,391,565.4 | 2,391,565.4 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,391,565.4 | 2,391,565.4 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 599,893.6 | 599,893.6 |
| 20 | 2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл | 2,991,459.0 | 2,991,459.0 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*/Мян.төг/*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 1,025,651.2 | 1,742,124.1 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 293,788.4 | 822,513.6 |
| 110 | Орлогын албан татвар | 113,035.6 | 174,073.9 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 113,035.6 | 174,073.9 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 34,740.5 | 41,982.6 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 146,012.3 | 606,457.1 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 19,579.8 | 10,395.0 |
| 1181 | Газрын төлбөр | 84,961.9 | 596,062.1 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 41,470.5 | 0.0 |
| 1183 | Бусад татвар | 0.0 | 0.0 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 133,436.3 | 146,582.6 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 133,436.3 | 146,582.6 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 598,426.5 | 773,027.9 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 600,393.3 | 672,404.6 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 600,393.3 | 672,404.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 544,826.5 | 641,931.4 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 282,845.8 | 339,212.9 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 35,759.9 | 43,339.4 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 68,936.9 | 19,415.4 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 28,676.8 | 46,726.6 |
| 2105 | Нормативт зардал | 600.0 | 600.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 20,853.6 | 6,405.8 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 11,622.0 | 14,772.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 26,294.9 | 104,731.5 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 69,236.7 | 66,727.7 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 55,566.8 | 30,473.3 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 425,257.9 | 1,069,719.5 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 707,348.5 | 319,381.1 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 707,348.5 | 319,381.1 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 707,348.5 | 319,381.1 |
| 2260 | Гадаад эх үүсвэрээр | 0.0 | 0.0 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -707,348.5 | -319,381.1 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | 0.0 | -137,000.0 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 0.0 | 137,000.0 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | -282,090.6 | 613,338.4 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 906,489.0 | 624,398.4 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 624,398.4 | 1,237,736.7 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Тайлангийн үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|---|---|---|
| II НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,782,021.1 | 1,079,194.0 |
| 21 УРСГАЛ ЗАРДАЛ | 770,476.2 | 635,612.5 |
| 210 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 749,141.7 | 614,508.5 |
| 2101 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 344,432.3 | 339,212.9 |
| 2102 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 50,706.5 | 43,339.4 |
| 2103 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 95,317.8 | 76,854.1 |
| 2104 Хангамж, бараа материалын зардал | 56,055.8 | 42,390.4 |
| 2105 Нормативт зардал | 600.0 | 600.0 |
| 210503 Нормын хувцас, зөөлөн эдлэл | 600.0 | 600.0 |
| 2106 Эд хогшил, урсгал засварын зардал | 41,041.6 | 30,124.9 |
| 2107 Томилолт, зочны зардал | 15,133.2 | 14,052.0 |
| 2108 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 9,575.3 | 7,809.0 |
| 2109 Бараа үйлчилгээний бусад зардал | 136,279.2 | 60,125.8 |
| 213 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 21,334.5 | 21,104.1 |
| 2132 Бусад урсгал шилжүүлэг | 21,334.5 | 21,104.1 |
| 22 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 860,406.2 | 306,581.5 |
| 23 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 151,138.7 | 137,000.0 |
| III ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,782,021.1 | 1,147,343.2 |
| 31 УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 345,921.7 | 345,921.7 |
| 32 ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 796,229.5 | 697,097.1 |
| 35 ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 639,869.9 | 104,324.4 |
| 4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 573,318.0 |
| 5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 641,467.1 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан** */Мян.төг/*

| | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|
| II НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 41,444.5 |
| 21 УРСГАЛ ЗАРДАЛ | 41,444.5 |
| 210 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 37,078.0 |
| 2103 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5,781.0 |
| 2107 Томилолт, зочны зардал | 720.0 |
| 210702 Дотоод албан томилолт | 720.0 |
| 2108 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 22,783.4 |
| 210801 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 22,783.4 |
| 2109 Бараа үйлчилгээний бусад зардал | 3,457.4 |
| 210901 Бараа үйлчилгээний бусад зардал | 3,457.4 |
| 213 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,366.5 |
| 2133 Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 4,366.5 |
| 213403 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 4,366.5 |
| I ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 41,444.5 |
| 1311 Нэмэлт санхүүжилтийн орлого | 41,444.5 |
| 131104 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 25,090.9 |
| 131105 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 16,353.6 |

## 3. Аудитын илрүүлэлт

### *3.1 Сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал*

Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 62,334.5 мянган төгрөгийн зөрчилд 1 хугацаатай албан шаардлага хүргүүллээ.

*3.1.1 Албан шаардлага*

- Нийт 13 нэр төрлийн татварын орлогоос 5 нэр төрлийн 62,334.5 мянган төгрөгийн татварын орлогыг батлагдсан төлөвлөгөөнөөс дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.19-т /*Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах*/, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т /*Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ*/, 41.2.1-т /*Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх*/ заасныг тус тус зөрчсөн байна.

## *3.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал*

Сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

*Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:*

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Засаг даргын Тамгын газар | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 1 | | 1 | | | | | |
| 3 | Мал хамгаалах сан | 1 | | 1 | | | | | |
| 4 | Хоршоо хөгжүүлэх сан | 1 | | 1 | | | | | |
| 5 | Орон нутгийн хөгжлийн | 1 | | 1 | | | | | |
| 6 | Байгаль хамгаалах сан | 1 | | 1 | | | | | |
| | **НИЙТ** | 6 | 1 | **5** | | 1 | | | |

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 450,929.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 85,115.4 мянган төгрөгийн 6 алдааг аудитын явцад залруулж, 18,234.3 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 346,567.8 мянган төгрөгийн 9 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 1,012.0 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 81.3 хувийг залруулагдаагүй, 18.7 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 53,225.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 13,131.5 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 13,273.0 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 24,367.6 мянган төгрөгийн 12 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 2,453.1 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж, 1 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 89.3 хувийг залруулагдаагүй, 10.7 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

***Сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийн үндэслэл***

Төсөвт байгууллага, тусгай зориулалтын сангуудын 2023 санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрын аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар ЗДТГ, ОНХС -д хүргүүлсэн 346,567.8 мянган төгрөгийн 5 албан шаардлага, МХС-д өгсөн 2,065.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт буюу нийт 348,632.8 мянган төгрөгийн зөрчил бүрэн хэрэгжиж, СХС-д хүргүүлсэн 16,113.2 мянган төгрөгийн төлөбрийн акт, Засаг даргад хүргүүлсэн 62,334.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага буюу нийт 78,447.7 мянган төгрөгийн зөрчлийг нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хамруулан авч үзлээ. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 1,068.1 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 12,879.4 мянган төгрөгөөр буюу 12.0 дахин бага байна.

Иймд Баянжаргалан сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд **“Өөрчлөлтгүй”** дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

| № | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Засаг даргын Тамгын газар | 4 | 83,321.4 | | | 4 | 83,321.4 | 4 | 83,321.4 | | | | |
| 2 | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | | | | | | | | | | | | |
| 3 | Мал хамгаалах сан | 1 | 1,494.0 | | | 1 | 1,494.0 | 1 | 1,494.0 | | | | |
| 4 | Байгаль хамгаалах сан | 1 | 300.0 | | | 1 | 300.0 | 1 | 300.0 | | | | |
| 5 | Хоршоо хөгжүүлэх сан | | | | | | | | | | | | |
| 6 | Орон нутгийн хөгжлийн | | | | | | | | | | | | |
| 7 | Нэгтгэсэн санхүүгийн тайлан | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | |
| | Дүн | 6 | 85,115.4 | | | 6 | 85,115.4 | 6 | 85,115.4 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

| д/д | Байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс: | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Засаг даргын Тамгын газар | 4 | 22,674.9 | | | 4 | 22,674.9 | | | | | | |
| 2 | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 2 | 56.1 | 1 | 56.1 | | | | | | | | |
| 1 | Мал хамгаалах сан | 2 | 2,065.0 | 1 | 2,065.0 | 1 | | | | | | | |
| 3 | Байгаль хамгаалах сан | 1 | 1,012.0 | | | | | 1 | 1,012.0 | | | | |
| 4 | Хоршоо хөгжүүлэх сан | | | | | | | | | | | | |
| 5 | Орон нутгийн хөгжлийн | 1 | - | | | | | | | 1 | | | |
| 6 | Нэгтгэсэн санхүүгийн тайлан | - | - | | | | | | | | | | |
| | **Нийт зөрчлийн дүн** | **10** | **25,808.0** | **2** | **2,121.1** | 5 | 22,674.9 | 1 | 1,012.0 | **1** | **-** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:**

| № | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | |
| 1 | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 1 | | | | 1 | | | |
| | Дүн | 1 | | | | 1 | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | | |
| 1 | Засаг даргын Тамгын газар | 1 | | | | | | 1 | |
| 2 | Орон нутгийн хөгжлийн | 3 | 323,892.9 | | | 2 | 323,892.9 | 1 | |
| 3 | Нэгтгэсэн санхүүгийн тайлан | 1 | 62,334.5 | | | 1 | 62,334.5 | | |
| 4 | Хоршоо хөгжүүлэх сан | 1 | 16,113.2 | 1 | 16,113.2 | | | | |
| | Дүн | 6 | 386,227.4 | | | 3 | 386,227.4 | 2 | |
| | Нийт дүн | 7 | 402,340.6 | 1 | 16,113.2 | 4 | 386,227.4 | 2 | |